МЭДЭЭ · 2022 оны 6-р сарын 9

“ХҮҮХДИЙН ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД СУРГАН ХҮМЖҮҮЛЭГЧИЙН ОРОЛЦОО” СЭДЭВТ ЭССЭ БИЧГИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Архангай аймгийн прокурорын газраас “Хүүхдийн эрх” нэгдсэн аяны хүрээнд “Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд сурган хүмүүжүүлэгчийн оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 5 сургуулийн 350 орчим багш, сурган хүмүүжүүлэгч нарын дунд зохион байгууллаа.

Уралдаанд тус аймгийн Эрдэнэбулган сумын 2 дугаар сургуулийн түүх нийгмийн

ухааны багш П.Амарсанаа, лабораторийн 1 дүгээр сургуулийн түүх нийгмийн ухааны багш Д.Лхагважаргал, 2 дугаар сургуулийн түүх нийгмийн ухааны багш М.Мянганбэлэг нар шагналт байранд шалгарсан байна.

Хүүхдүүдийн толь бол багш нар, багш нарын толь бол хүүхдүүд мөн.

Багш сурган хүмүүжүүлэгчид бол Хүүхдийг өдөр тутмынхаа үйл ажиллагааг зөв зохион байгуулахад нь чиглүүлэн тусалж байх ёстой. Өөрөөр хэлбэл хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, санаачилга, өөрийн удирдлагыг хөгжүүлэх үзэл санаанд тулгуурлан хөгжүүлэх үүрэгтэй.

Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн баримт бичгүүд маш олон, Хүүхдийн эрхийг хамгаалдаг 120 гаруй ТББ –ууд байна.

Тэгвэл яагаад хүүхдийн эрх зөрчигдөөд байна вэ? Хэний оролцоо чухал вэ? гэх мэт олон асуулт ар араасаа цуварсаар.....

Багш сурган хүмүүжүүлэгчид бид хүүхдүүдтэй цаг минут бүрт хамтран ажиллаж, зөвлөн тусалж байдаг. Иймээс тэд алхам тутамдаа Хүүхдийн хөгжих, хамгаалуулах эрхийг хамгаалж байх үүрэгтэй.

Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд **Багш сурган хүмүүжүүлэгчид дараах байдлаар оролцдог**. Үүнд:

1. Сургуулийн орчин дахь дээрэлхэлт, гадуурхал, сошиал орчин дахь аюулгүй байдлын зөрчил, багш ажилтнуудын ёс зүйгүй үйлдэл 2021 онд хэд хэдэн удаа гарсан. Судалгаанаас дүгнэхэд 2021 онд багш, ажилтны ёс зүйн зөрчлийн талаарх 58 өргөдлийг аймаг, дүүргийн Ёс зүйн зөвлөл ирүүлсэн бөгөөд ёс зүйн зөрчил гэдэг нь нотлогдоогүй 17 өргөдөл гомдлыг буцаажээ.Ёс зүйн зөрчил гаргасан 41 албан хаагчид сахилгын хариуцлага оногдуулсан байна.Энэ байдлыг таслан зогсоохын тулд боловсролын салбарт сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн. Тэгвэл эхэлсэн ажлаа үр дүнд хүргэж үүнд чиглэсэн үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж боловсролын салбар 2022 оныг Ёс зүйн жил болгон зарласан.

2. Багш-Эцэг эхийн хамтын ажиллагаа: Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд эцэг эхийн оролцоо бас их хэрэгтэй. 2022 оны 4,5-р саруудад манай сургууль дээр Хүүхдийг хүмүүжүүлэх эрэг арга, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх" сургалтыг Эцэг эхчүүдэд хийсэн. Эндээс дараах дүгнэлтэнд хүрсэн.

- ✓ Эцэг эхчүүд энэ сургалтыг өөрийн албан байгууллага дээрээ хийж өгнө үү гэсэн хүсэлтийг аж ахуйн нэгжийн албан хаагч, төрийн байгууллагын ажилтан, хувираа хөдөлмөр эрхлэгчид тавьж байхыг бодоход Багш нарын сургалт үр дүнгээ өгсөн өнөөгийн хэрэгцээ шаардлага байгааг илэрхийлж байна. Хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдол байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх энгийн боловч арга замаа мэдэхгүй байсан. Үүнийгээ сургалтаас ойлгосон.

3. Гэр бүл дотор хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдлыг багш нар л хамгаас түрүүлж ялангуяа анги удирдсан багш мэддэг. Мэдсэн даруйдаа эрхийг хамгаалахаар оролцож эхэлдэг, энэ нь ч үр дүнд хүрдэг. 4. Төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Орон нутгийн байгууллага, архангай аймгийн Хүний эрхийн хороо... байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй.

5. Сургуулийн орчинд: Оролцоог хангаж байгаа жишээ гэвэл:

- ✓ ТНУ-ны багш нар 7-9 ангийн хүүхдүүдэд Нийгмийн хичээлээр "Хүний эрх ба хууль", 10-12 ангийн хүүхдүүдэд "Эрх зүй"-н бүлэг сэдвийн хүрээнд Хүүхдийн хөгжих эрх, хүүхдийн хамгаалуулах эрхийн талаар хичээл заадаг
- ✓ 1-12 ангид "Иргэний ёс зүй"- н хичээлээр Хүүхэд хамгаалал, монгол өв уламжлал, ирээдүйн Монголын шинэ иргэн хэрхэн төлөвших арга замыг заадаг. Энэ мэтээр багш, хүүхдүүдтэйгээ олон арга замаар хүссэн ч хүсээгүй ч холбогддог.

Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд багш сурган хүмүүжүүлэгчид хэрхэн оролцож болохыг дурдлаа.

Хүний эрхийн үндэсний комисс Иргэд олон нийтэд чиглэсэн Хүний эрхийн боловсрол олгох сургалтыг 2022 оны 1-р улиралд 9 удаа 385 иргэнд хүний эрхийн боловсрол түгээж ажиллажээ.

Ирээдүй хойч үе рүүгээ илүү холыг харж хүүхдүүдтэй хамгийн ойр байдаг багш сурган хүмүүжүүлэгч (нийгмийн масс их) - нарт сургалт, сурталчилгааг түлхүү хийвэл Хүүхдийн эрх зөрчигдөх нь багасна. Яагаад гэвэл багш нараас хүүхдүүд их үлгэр дууриал авдаг түүнийгээ эцэг эхтэйгээ ярилцдаг, түүнийг эцэг эх нь албан байгууллага дээрээ мэдээлэл солилцох замаар түгээн дэлгэрдэг.



Ашигласан материал:

- 8, 10, 11, 12 ангийн сурагчдаас авсан судалгаа
- Хүүхдийн эрхийн тухай конвенци I хэсэг
- Хүүхдийн эрхийн тухай хууль III бүлэг
- Багш сурган хүмүүжүүлэгчдээс авсан судалгаа

Архангай аймгийн Лаборатори I сургуулийн багш Даваадоржийн Лхагважаргал

“ХҮҮХДИЙН ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧИЙН ОРОЛЦОО”

Хүний эрх тэр дундаа хүүхдийн эрх гэж юу вэ? Хүмүүсийг хүн гэдэг утгаар нь ямар нэг алагчлал, ялгаварлалгүйгээр адил тэгш хандах тухай асуудал юм. Дэлхий дээр амьдарч буй хэнбуйгай ч арьс өнгө, нийгмийн гарал, шашин шүтлэг, мэдлэг боловсрол, баян ядуу, зэргээс үл хамааран бүгд эрхэм нандин, үнэ цэнтэй байдаг. Хүн бүр төрсөн цагаасаа эхлэн эрхээ эдлэх бөгөөд эдгээр эрх нь заяамал, язгуур шинжтэй байдаг. Тэгвэл эдгээр заяамал, язгуур эрхүүдээ хүүхдүүд эдлэж чадаж байна уу, хэрэв хэрэгжиж чадахгүй бол тэдэнд хамгийн ойр ажилладаг багш сурган хүмүүжүүлэгчид бид хэрхэн яаж туслах вэ?

Ерөнхий боловсролын сурагчдад долдугаар ангиас нь эхлэн нийгэм судлал хичээл эхлэн ордог бөгөөд тус хичээлээр “хүүхдийн эрх ба үүрэг” гэж ордог. Ийм ч учраас миний бие өөрийн ордог ангиуд болох 7-9 ангийн сурагчдаас түүврийн аргаар гурван асуулгатай судалгаа авлаа. Үүнд нэгт хүүхдүүд та нарын эрх зөрчигдөж байна уу, хөөрт хаана буюу гэр бүл, сургууль, найз нөхөд, гудамж талбайд уу, гуравт багш нар нь тусалж чадах уу? Гэсэн асуултаар хүүхдүүдийн эрхийн зөрчлийн талаар илрүүлэхийг хичээлээ. Судалгаанд маань нийт 85 сурагч хамрагдсанаас эхний асуулт болох хүүхдүүд та нарын эрх зөрчигдөж байна уу гэсэн асуултанд 40 сурагч тийм, үлдсэн 45 сурагч нь үгүй гэж хариуллаа. Харин хоёр дахь асуулт болох хаана түлхүү зөрчигдөж байгаа тухай асуухад давхардсан тоогоор гэр бүлд 7, сургууль дээр 21, найз нөхдийн дунд 17, гудамж талбайд 13 гэж бичсэн байна. Эдгээрийг ерөнхийд нь нэгтгэвэл найз нөхдийн дунд хувийн нууцаа хамгаалуулмаар байна, эрүүл ахуулгүй орчинд амьдрах, хүүхдүүдийн оролцооны эрх, бид хаана ч явсан ганцаараа явж байгаа учир хамгаалуулах эрх, хүүхдүүдийг ялгаварлахгүй байх, суралцах эрх, охидын бэлгийн дарамт их байх зэргээр зөрчигдөж байна гэж бичсэн байна. Гурав дахь асуулт болох багш нар нь та нарт хэрхэн яаж туслах вэ гэсэн асуултанд 30 сурагч нь эрх зөрчигдөөгүй учир туслах шаардлагагүй, гэсэн бол 56 сурагч дараах байдлаар туслах боломжтой гэж үзсэн байна. Тэдгээрээс дурьдвал “бид багш нартайгаан илэн далангүй, нээлттэй ярилцах, зөвөлгөө авах, ойлголцох, урам зориг авах, шүүмжлэхгүй байх, нийтэч байх, ялгаж харьцахгүй байх, олон хүүхдүүдийн дунд загнахгүй байх, эцэг эхэд минь биднийг ойлгуулах тал дээр хэлж өгөх, эрт тараах, завсарлуулах, эрх зөрчиж байгаа хүүхдүүдэд шаардлага тавих, бэлгийн хүчирхийлэл хийсэн хүмүүсийг чангаар шийтгэмээр байна иймд хуулийг чангатгах тал дээр цааш нь дуу хоолой болоод өгөөч” гэх мэтээр сурган хүмүүжүүлэгчиддээ хандаж үгээ дайсан байна.

Биднийг арван жилийн сурагч байхад “хүмүүжлийн цаг, ангийн ажлын цаг ” гэж анги удирдсан багшид өгдөг байсан. Түүгээр багш ангийнхаа сурагчидтай ярилцах болон янз бүрийн хүмүүжлийн ажил зохиож хүүхдүүдийнхээ дунд орж, тэдний сэтгэл санааг ямар байгааг тандаж мэдэх, анги хамт олны уур амьсгалыг сайжруулахад чиглэгдсэн олон сайхан арга хэмжээ авч ажилладаг байсан. Энэ цаг үед анги удирдсан багш өөрийнхөө хичээлийн цагаас хумслан байж ангийнхантай ажиллаж байгаа хэдий ч энэ нь тэр бүр хангалттай байж чадахгүй байна. Тийм учраас сурагчдын дунд тэдний эрх зөрчигдөх бас нэгэн үндэслэл суурь нь болж байна. “Цаас хэдий нимгэн ч чичихээс нааш цоорохгүй, хүн хэдий ухаантай ч хэлэхээс нааш санахгүй” гэсэн ардын сайхан үгээ санаж энэхүү үйл ажиллагааг буцааж сэргээх нь зүйтэй гэж бодож байна.

Мэдээллийн энэ эрин зуунд амин хувиа хичээсэн, хүний мөс чанар гээгдсэн хэцүүхэн нийгэмд “Z” үеийн хүүхдүүдэд мэдлэг боловсрол олгох гэж яваа сурган хүмүүжүүлэгчид бид тэндэндээ аль болох ойр байж, тулгамдаж байгаа асуудлуудыг зохих түвшинд нь шийдвэрлэж, бүүр боломгүй бол холбогдох газруудад нь хандаж, сурагчдынхаа “ГҮҮР” нь болж ажиллах шаардлагатай байна. Харамсалтай нь хөрсөн дээрээ тулгамдаж байгаа зүйлсийг бодлого боловсруулагч нар нь анхаарч харахгүй, зүгээр л дээгүүр хөвсөн бодлого гаргаж ирж байгаа нь тун чиг харамсалтай. Дээрх судалгаанд тулгуурлан харвал “орон нутгийн түвшинд гэрэлтүүлгийг сайн хийх, айлууд нохойгоо уях, өвлийн цагт гудамжинд угаадасаа ил задгай асгахгүй байх, архидалттай тэмцэх” ажлууд дээр түлхүү анхаарах, харин бодлого боловсруулагч нарийн хувьд хүчирхийлэлийн хууль болон гэр бүлийн хуулийг илүү сайн чангатгаад өгөх нь нэн чухал байна. Хэдийгээр сургууль дэргэдээ сэтгэл зүйчтэй болсон ч гэсэн ганц хүн олон хүнд хүрч ажиллана гэдэг бас л чанга асуудал. Ганц дайчин ганцаардахгүй гэж тэд маань мэрийгээл байгаа... Гэсэн ч багш сурган хүмүүжүүлэгчид бидний хувьд сурагчидаа илүү сайн мэдэрч, ойлгож, тэдэнд туслахын тулд “сэтгэл зүйч”-ээр дахин мэргэших сургалтанд хамрагдвал тэдний эрх зөрчигдөхөөс хамгаалж, сэргийлж чадна гэж бодож байна. Эх орны минь ээзд болсон сурагчид маань ямарваа нэгэн эрхийн зөрчилгүй сурч, боловсрон хөгжих болтугай.

Архангай аймаг Эрдэнэбулган сум Хоёрдугаар сургуулийн ТНУ-ны багш М.Мянганбэлэг

Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд сурган хүмүүжүүлэгчийн оролцоо

Хүүхэд гэж хэн бэ? гэж хэн нэгнээс асуувал “Хүүхэд бол аз жаргал юм”, “Хүүхэд бол аав ээжийн амьд эрдэнэ юм” тэд дандаа инээж байгаасай, айх аюулгүй байгаасай ... гэсэн үгс хөврөх нь дамжиггүй.. Харин гэтэл хүүхэд бүр өдөр бүр инээж , айх айдасгүй амар тайван амьдарч байгаа болов уу? Яг одоо нэгэн жаахан бүлтгэр үр нүдэндээ нулимстай нүүрэндээ гунигтай зүрхэндээ айдастай бүлтэлзээд хаа нэгэн газар үргэсэн янзага шиг зогсож байх вий дээ.... Ингэзд л бодоход зүрх зүсэгдэх шиг амьсгал давчидах шиг. Хүүхдийн эрх хэрхэн зөрчигдөж байгаа тухай мэдээллийг өнгөцхөөн харахад л 2022 оны 4 дүгээр сарын байдлаар хүүхдийг хувцас, хоол, хүнс, орон байраар зориуд гачигдуулсан зөрчил 23, Хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, өв залгамжлах, эсхүл ажил үйлчилгээний хөлс, урамшуулал авах эрхийг хязгаарласан зөрчил 24, хүүхдийг сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан зөрчил 20 гэх зэргээр нийт зөрчлийн хэргийн 1412 буюу 96.1 хувь нь хүүхдийн бие махбодид халдсан, үл хайхарсан, хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн зөрчил эзэлж байна гэсэн мэдээлэл байна. Энэ бол хүүхдийн тулгуур 4 эрх болох эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрх зөрчигдсөөр байгаа тод илрэл юм.. Хүчирхийллийг хүүхдийн эрхийн конвенцид зааснаар “гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлийн бүх хэлбэр” хэмээн тодорхойлсон аж.

Тэгвэл энэ хүчирхийллийн эсрэг багш хэмээх эрхэм алдрын эзэд болсон бид юу хийж чадах вэ? Эрхэм шавь нараа хүчирхийлэлд өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? гэдэг бол маш чухал томоохон асуудал болон урд урган гарч ирсээр байна. Хүүхдийн эрхийг хангах хамгаалах нь иргэн бүрийн болон төрийн үүрэг бас багш миний үүрэг. Иймээс хүүхдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэхийн тулд би юуг хамгийн түрүүнд хийх ёстой вэ?

- Хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэлтэй болгох гэмт хэрэгт холбогдсноор гарч ирэх хор уршгийн талаар бодит мэдээллийг хууль сахиулах байгууллагуудтай хамтран сургууль болон өөрийн , ангийн ажлын төлөвлөгөөнд тусган тогтмол зохион байгуулж хэвших
- Гэр бүлийн зөрэг харилцаа хаңдлага, хүүхдийн хүмүүжлийн талаар тэдний асран хамгаалагч нарт сургалт явуулдаг, ар гэрийн эрсдлийн талаар судалгаа хийдэг, тусгайлан зөвлөгөө өгдөг, гэр бүлийн зөрчлийг зөрэгээр шийдвэрлэх арга замуудын талаар мэдээлэл, зөвлөмжөөр хангах, хүүхдийн хүмүүжлийн зөрэг аргуудыг сурталчилдаг түгээн дэлгэрүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран аян, уралдаан тэмцээнийг төрийн болон хувийн хэвлшийн байгууллагууд, эцэг эх асран хамгаалагч нарт зохион байгуулдаг байх
- Хүүхдийн эрхийн талаар төрөөс явуулж байгаа бодлого, холбогдох хууль тогтоомж, зохион байгуулж байгаа арга хэмжээний талаар өргөн мэдлэг, чадвартай , цаг үеийн талаар мэдээллийг түргэн шуурхай олж авдаг байх
- Цахим орчны эрсдлийн талаар мэдээ мэдээлэл, цахим орчны зөв хэрэглээний талаар эцэг эхчүүд, сурагчдад мэдлэг мэдээлэл тасралтгүй хүргэх
- Хүүхэд эрхээ зөрчигдөж байгаа талаар холбогдох байгууллага, албан тушаалтан багш нийгмийн ажилтаңд хандах сэтгэл зүй, хандлагыг бий болгох нь чухал юм.

Эцэст нь дүгнэн хэлэхэд сургуулийн удирдлагууд, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш ажилчид, эцэг, эх асран хамгаалагч, хүүхдийн эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж хүүхдийг эрсдлээс хамгаалах эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд холбогч гүүр нь байж, хүүхдийн эрхийн дуу хоолой, хүүхдийн эрхийн төлөө тэмцэгч, хууль дүрмийг хэрэгжүүлэгч, хүчирхийллийг илрүүлэгч , тэдний сайн анд нөхөр, хамгийн шилдэг зөвлөгч, хамгийн дотны итгэлт хүн нь байснаар хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж чадна.

Эрдэнэбулган сумын II сургуулийн түүх нийгмийн ухааны багш П.Амарсанаа

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2224